

2025 он 9 сар 10 өдөр

Дугаар 04/25

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө
нэмэгдүүлэх тухай*

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.1, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16, 2025 оны 9 сарын 10-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын №2 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө буюу нэгж хувьцааны үнийг 600 (зургаан зуун) төгрөг болгон нэмэгдүүлсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж өөрчлөлтийг санхүүгийн тайланд тусгах, хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Н.Эрдэнэтулга)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Н.ХОСБАЯР

2015 он 9 сар 10 өдөр

Дугаар 05/15

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн дүрэм нэмэлт өөрчлөлт
оруулах тухай*

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.5, 62 дугаар зүйлийн 62.1.1 дахь хэсэг, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.1 дэх хэсэг болон 2025 оны 9 сарын 10-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын №3 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай.
 - 1.1. Ард Даатгал ХК-ийн дүрмийн 1.5-д “Компанийн албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305 тоот” гэж заасныг “Компанийн албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 17 давхар, 1710 тоот” гэж өөрчлөх;
 - 1.2. Компанийн дүрмийн 4.1-д “Компани нь 200 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 25,000,000 ширхэг энгийн хувьцаатай байна” гэж заасныг “Компани нь 600 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 25,000,000 ширхэг энгийн хувьцаатай байна” гэж өөрчлөх;
2. Энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт заасан нэмэлт өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Н.Эрдэнэтулга)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Н.ХОСБАЯР